



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2023 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 345

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн  
төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүнийг  
чөлөөлөх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын 4.7.9 дахь заалт, Засгийн Газрын Хэрэг Эрхлэх газраас 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр ирүүлсэн ХЭГ/989 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын саналын дагуу Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах референт Д.Балжинням “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөр тасалбар болгон чөлөөлсүгэй.

2. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ